

DIOS PATRIA LIBERTAD

Доминиканы
Бүгд Найрамдах
Улсаас
МЭНДЧИЛЖ
байна!



Сайн уу?
Намайг Марго
гэдэг. Энэ бол
миний дүү
Паоло.



Бид Доминиканы Бүгд
Найрамдах Улсаар
аялж байна. Ирээд,
бидэнтэй нэгдээрэй!



Өнгөрсөн жил бошиглогч Доминиканы Бүгд
Найрамдах Улсад айлчилж, хүмүүст хандан
испаниар ярьсан.



Доминиканы Бүгд Найрамдах Улс нэг ариун сүмтэй
ба энэ нь Сан-Домингод байдаг. Дээр нь "Santidad al
Señor: La Casa del Señor" гэж бичсэн байдаг ба энэ нь
"Их Эзэний өргөөнд: Ариунаас ариун" гэсэн утгатай.

Доминиканы Бүгд
Найрамдах Улс

Доминиканы Бүгд Найрамдах Улс
нь Карибын тэнгист, Хаити улстай
хиллэсэн арал дээр оршин тогтнодог.
Доминиканы Бүгд Найрамдах Улсад 10
орчим сая хүн амьдардгийн 130000 нь
Сүмийн гишүүд юм.

Сан-Доминго ★

Доминиканы Бүгд
Найрамдах Улсад
хүмүүс испани
хэлээр ярьдаг.
Энэ хүү El Libro
de Mormón буюу
Мормоны Номыг
барьсан байна.



Доминиканы Бүгд Найрамдах Улсад
олон хүүхэд бэйсболл тоглох дуртай.
Энэ бол тухайн улсад хамгийн өргөн
тархсан спорт юм.



Доминиканы Бүгд Найрамдах
Улсын иргэд халуун орны
жимс, ногоог өргөн хэрэглэдэг.
Энэ хөвгүүд наргил модны сүү
ужж байна.

Та бас
Доминиканы
Бүгд Найрамдах
Улсаас ирсэн үү?
Бидэнд захидал
бичээрэй! Бид
таныг сонсохыг
хүсэж байна.

Доминиканы Бүгд
Найрамдах Улсаар
бидэнтэй хамт аялсанд
баярлалаа. Одоо бид
дараагийн аялалдаа
гарлаа!



Доминиканы Бүгд Найрамдах
Улсын зарим найзтайгаа уулзъя.



"Би Хүүхдийн хэсгийн
жаахан хүүхдүүдийг
шуугилдах үед тэдэнд
туслах дуртай. Би цаасан
дээр дуу бичээд, тэдэнд
дуулахад нь тусалдаг.
Би мөн судраас уншиж
ойлгоход нь тэдэнд
тусалдаг."
Амбар О., 11 настай,
Доминиканы Бүгд Найрамдах Улс



"Би Есүст хайртай
бөгөөд Түүнтэй маш ойр
байгаагаа мэдэрдэг.
Би бас сүмийн дуулал
болон Хүүхдийн хэсгийн
дуунуудад дуртай."
Иан Р., 8 настай,
Доминиканы Бүгд Найрамдах Улс